



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/244

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль, тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан Шижээдарамын Минжүүрдоржийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан Ганпүрэвийн Отгонбаярт үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2004 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 90 дугаар захирамжийн Шижээдарамын Минжүүрдоржид холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj

2024100498

сумын Засаг даргын 2024 оны
17-ны өдрийн
19-дугаар сарын
17-ны өдрийн
19-дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлсэн болон шилжүүлэн авсан иргэний жагсаалт

Шилжүүлэн авч буй ААН, иргэний нэр	Регистрийн дугаар	Газрын хэмжээ /га/	Хугацаа /жил/	Газрын байршил	Зориулалт	Нэгж талбарын дугаар	Шилжүүлсэн ААН, иргэний нэр	Шилжүүлсэн үндэслэл
Ганпүрэв Отгонбаяр	C385040219	100	10	7-р баг, Дундбаян	Үр тарианы усалгаагүй тариалан	2314003611	Шижээдарам Минжүүрдорж	Өөрийн хүсэлтээр
Дүн		40						